.. дугаартай албан бичгийн Хавсралт 1

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2023 оны эхний хагас жилээр
Байгууллагын нэр:
БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:
Тайлан бичсэн мэргэжилтний нэр, албан тушаал, холбогдох дотуур болон гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг:

| | A | B | C | D | E | F | G | H |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа /өөрийн байгууллага болон орон нутагт хамааруулж тайлан гаргана/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилт */Strengths/* /зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэр, шийдвэр байгаа бол заавал бичнэ/ | Сул тал */Weaknesses/* | Сайжруулах боломж */Opportunities/* | Хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй зүйл */Threats/* |
| **Нэг. Эрүүл мэндийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг нь хамгаалах** | | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран үнэлэх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх | Үнэлгээний тайлан; Шинэчилсэн дүрэм, журмын тоо | | | Байгууллагын хэмжээнд:<br><br>Хүчил төрөгчийн баллонтой ажиллах журамГамшиг ослын болон онцгой тохиолдлын үед ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллаж байна. Галын аюулгүй байдлыг хангаж галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2 жилээр 2023 он хүртэл сунгуулсан. Байгууллагын хэмжээнд нийт 23 ширхэг галын гидрант 54 ширхэг галын хортой, нийт 4 ширхэг орц гарцын талаар нийт, эмнэлгийн ажилчдад мэдээлэл өгсөн. | | | |
| 2. | Эрүүл мэндийн байгууллага бүрт ослыг тэглэх, осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх<br>— Ослын тоо<br>— Мэргэжлийн шалтгаалсан өвчлөлийн тоо | Үйл ажиллагааны төлөвлөгөө. Хэрэгжилтийн тайлан./Хавсралтаар ирүүлэх/ | | | 2018-08-01 өдрийн захирлын Б/124 тоот тушаалаар ХАБЭ ажилтнаар лабораторийн их эмч Б.Сүхболдыг, томилон ажиллуулж байна. 2021 оны 1 сард АӨСҮТ-н гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулан | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлж байна.<br><br>2020-10-01 өдрийн захирлын Б/217 тоот тушаалаар тус төвийн ажилчдын хяналтын эмчээр томилогдсон И.Ёндондаш хүүхэд асрах чөлөө авсан тул И.Мөнхзаяа эмчийг нөхөн томилсон байна. 2021-06-28 өдрийн А/27 тоот тушаалын 2-дугаар хавсралтаар “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ыг батлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Одоогоор мэргэжлийн өвчнөөс шалтгаалсан өвчлөл, осол гараагүй байна. ажилтантай хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж баталгаажуулан, ажиллах хугацаа, ажил үүрэг, ажил амралтын цагийг тодорхойлон, цалин хөлс, хөнгөлөлт, хангамжийг тогтмол хугацаанд олгож байна. Хөдөлмөрийн аюулгүй орчныг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тусгасан ажлыг бүрэн хэрэгжүүлэн гэрээний хэрэгжилтийг улирал бүрээр дүгнэн ажиллаж байна. АӨСҮТ-ийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 2022-2024 оны хамтын гэрээг | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлан Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээр баталгаажуулан 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. | | | |
| 3. | Эрүүл мэндийн байгууллага, нэн тэргүүнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар үе шаттай хийлгэх | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ. Сайжруулах ажиллагааны тайлан /Тайланг хавсралтаар ирүүлнэ үү/ | | Нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэсэн байна. | Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгүүлэхээр ажиллаж байна. | | | |
| 4. | Эрүүл мэндийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг холбогдох талуудтай хамтран тогтмол хугацаанд үнэлж, шинэчлэх | Үнэлгээ, шинэчлэл | | | Монгол улсын хууль, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журам, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан журам, Эрүүл мэндийн сайдын албан даалгаврыг, Байгууллагын дотоод журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | |
| 5. | “Тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д салбарын ажил, мэргэжлийн жагсаалт, шинээр нэвтэрч байгаа техник, технологитой уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах | Шинэчлэгдсэн жагсаалт | | | 2004 оны Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 77 дугаар тушаалын дагуу Тэтгэврийг хөнгөлөлтэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Эм зүйч, туслах сувилагч, угаалгын ажилтны ажлын байрыг нэмэлтээр оруулах | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саналаа хүргүүлж байна. | | | |
| 6. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг эрүүл мэндийн ажилтнуудад тогтмол зохион байгуулах | Зохион байгуулагдсан сургалтын тоо | | | | | | |
| 7. | Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны талаарх мэдлэгийг сайжруулах сургалтыг тогтмол зохион байгуулах | Зохион байгуулагдсан сургалтын тоо | | | | | | |
| 8. | Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгслээр бүрэн хангаж, тогтмол хугацаанд шинэчлэх | Зарцуулсан хөрөнгө | | | “Байгууллагын брэнд хувцаслалт”-ыг эмч, сувилагч, асрагч, хөтөч, туслах ажилтан зэргээр байгууллагын БРЭНД БҮҮК—ээр баталсан байдаг. 6 Цахим бүртгэгч 632,500 төгрөгийн хувцас хэрэглэлээр хангасан байна. | | | |
| 9. | Шөнийн ээлжинд гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг заавал биеэр амруулах эрх зүйн зохицуулалт бий болгож, хэрэгжүүлэх | Батлагдсан шийдвэр Биеэр амралтыг эдлүүлсэн баримт - ажлын цагийн бүртгэл, илүү цагийн мөнгө | Шөнийн цагийн нэмэгдэл 1000 | Шөнийн цагийн нэмэгдэл 2000 төгрөг хүргэх | Хөдөлмөрийн шинэчилсэн хуулиар ээлжээр ажилладаг ажилтны хуваарьт өөрчлөлт хийн ажилласан боловч эмч, эмнэлгийн ажилтны хүсэлт өргөдлийн дагуу, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.2.3 дугаар заалтаар ээлжийн хуваарийг 8/16 болон 24/72 цагаар байхаар тусган өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Шөнийн ээлжид ажиллаж байгаа эмч, сувилагч, асрагч, жижүүр нарт шөнийн цагийн нэмэгдлийг 1 цагийг 2000 төгрөгөөр тооцон олгодог. Мөн шөнийн ээлжид ажилласан эмч нарыг өдрийн | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 12.00 цагт ээлжээс буулган амралтыг биеэр амрааж байна. | | | |
| 10. | Эрүүл мэндийн байгууллага бүр албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн ажилтныг хууль эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлэх | Гэрээгээр хуульч ажиллуулдаг эсэх ? Дэмжлэг авах шаардлагатай ажилтны тоо / Дэмжлэг авсан ажилтны тоо | | | “Өмгөөллийн лоо стратеги” ХХК-тай 2022 онд хамтран ажиллах гэрээний хугацааг сунган ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн ажилтан байхгүй байна. | | | |
| 11. | Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх журмыг батлан, эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлэх | Батлагдсан журам Урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан | | | Хэвлийн Эход нийт – 57 ажилтан хамрагдсан Үүнээс; Аяны хүрээнд **33** Ажилтан : элэгний хоргүй хавдар:1, элэгний уйланхай:3, элэгний шохойжилт:4, элэгний өөхлөлт:FLI-4, FLII- 25, FLIII-3 цөсний хүүдийн чулуу:1, бөөрний чулуу 1, бөөрний уйланхай:1, Бусад 24 ажилтан хамрагдсан байна. | | | |
| 12. | Эрүүл мэндийн ажилтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг шинэчлэн баталж мөрдүүлэх | Багталгдсан журам, тайлан | | | 2023 он гарсаар шинэ ажилтанууд нэмэгдсэнээр мэдээлэлийн санг шинэчилсэн. Өвчлөлийн хувьд Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 58 /46.8%/, Зүрх судасны эмгэг 17 /13.7%/ дийлэнхи хувийг эзэлж байна. Иймээс 3р улиралд Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны үзлэгийг бүх ажилчдад хийхээр төлөвлөж байна.<br><br>Денкфармын монгол дахь төлөөлөгчийн газраас 75 ширхэг витамин D31000mg хүлээлгэн | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өгсөн .Бүх ажилчдадаа хуваан тасаг нэгжийн ахлахуудад хүлээлгэн өгсөн.<br> | | | |
| 13. | Элэгний С вирусийн халдвар илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудыг вирусийн эсрэг эмчилгээнд үргэлжлүүлэн үнэ, төлбөргүй хамруулах | Элэгний С вирусийн эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо Урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан | | | Элэгний В,С илрүүлэх шинжилгээг нийт 85 ажилтан, 28 резидент эмч нарт хийхэд 7 ажилтанд С вирус эерэг, 1 сул эерэг, 4 ажилтанд В вирус эерэг гарсан. | | | |
| 14. | Эрүүл мэндийн байгууллага ажилтнуудаа ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах | Гэрээгээр сэтгэл зүйч ажиллуулдаг эсэх Үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо, тайлан | | | Эхоны эмч Б.Лхагвасүрэн эмч нарын яриан дээр Элэгний өөхжилтийн талаар авах арга хэмжээ,сэргийлэлтийн талаар мэдээлэ хүргэсэн | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | |   | | | |
| 15. | Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндийн байгууллага хөдөлгөөн өрнүүлэх | Тоо | | | Энэ жилдээ- Эрүүл жиндээ аяны хүрээнд АӨСҮТ ийн нийт ажилчдын биеийн жингийн индексийг ( Биеийн жин,Өндөр) болон бүсэлхийн тойргийн хэмжээг тодорхойлон гаргасан.<br><br>Нийт 121 ажилтан хамрагдсан Үүнээс: Хэвийн жинтэй- 47, Жингийн дутагдалтай- 4, Илүүдэл жинтэй -43, Таргалалт I зэрэгтэй-22, Таргалалт II зэрэгтэй -5<br><br>Таргалалтын I болон II зэрэгтэй ,бүсэлхийн тойрог нь 90см дээш нийтдээ- 32 хүнд ЦЕШ, Биохими (Алат.Асат,Холестрин ,Триглицерид,Сахар) зэрэг 5 үзүүлэлтээр үзүүлэхэд Үүнээс; Диабеттай -1хүн, Сахар 5mmol/l ээс дээш 5 хүн байна. Холестрин ,Триглицерид ихэссэн 8 хүн ,Алат үзүүлэлт нь ихэссэн 3 хүн байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | |  | | | |
| **Хоёр. Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах** | | | | | | | | |
| 1. | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг үе шаттайгаар эхлүүлэх | төгсөлтийн дараах сургалтын төлөвлөгөө, тайлан | | | -Лавлагаа шалталын эмнэлэгт хамаарахгүй | | | |
| 2. | Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд зайн сургалт явуулах боломжийг бүрдүүлж, зайн сургалтын чиглэлийг өргөжүүлж, оролцогчдын тоог нэмэгдүүлэх | Зайн сургалтын төвтэй эсэх, зохион байгуулсан сургалтын чиглэл, тоо | | | -Лавлагаа шалталын эмнэлэгт хамаарахгүй | | | |
| 3. | Зайн сургалтын хэрэгцээнд үндэслэн сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтанд зайн сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах | Сургалтын төлөвлөгөө, Тайлан, хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | Жилд 1 удаа зохион байгуулагдсан | Хагас жилд 1 удаа зохион байгуулах | 2023 оны 04-р сарын 12-нд “Ургамлын тоосны харшил өвчний шалтгаан, өвөрмөц аллерген дархлаажуулах эмчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдэвт 1 багц цагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж төвийн эмч нар танхимаар болон нийслэл, орон нутгийн арьс, харшлын эмч нар, харшлаас сэргийлэх үндэсний хөтөлбөрийн орон нутгийн хамтран ажиллах багийн бусад мэргэжилтнүүд цахимаар хамрагдлаа.<br>Сургалтын зорилго: Монгол улсын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ургамлын тоосны харшлын урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, иргэдийг эрүүл мэнд экологийн боловсрол олгох. | Хөдөө орон нутгийн эмч, эмнэлгийн. Мэргэжилтнү үдийн цахим сургалтанд хамрагдахад шаардагдах техникийн хангамжийн асуудал. Сургалтын зар хүлээн авж мэдээллийг дамжуулах үйл явц байгууллага тус бүрт харилцан ялгаатайь зарим хөдөө | Техникийн хангамж, чадамжийг сайжруулах. Хөдөө орон нутгийн сургалт хариуцсан мэргэжилтнүүдтэй шууд харилцаа холбоо тогтоох боломж бүрдүүлэх. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Удирдсан багш/байгууллага: АӨСҮТ-ийн Харшлын лабораторын эрхлэгч, Биологийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Б.Сангидорж, АӨСҮТ Сургалтын алба, Лабораторийн тасаг<br>Сургалтын хугацаа: 1 өдөр<br>Сургалтад оролцсон оролцогчдын тоо: 19 аймгийн 65 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ЗДТГ-ын мэргэжилтэн, цаг уурын ажилчид. АӨСҮТ-ийн нийт 32 эмч.<br>Сургалтын зардал: Байгууллагаас зардал гараагүй.<br> | орон нутгийн эмч нар зар хүлээн аваагүй. | | |
| 4. | Улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр, байгууллагын санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах тоог нэмэгдүүлэх | Өндөр хөгжилтэй оронд сургалтад хамрагдсан эмч, сувилагч, мэргэжилтэн | 2 | 2 | ЭМЯ-ны аас зохион байгуулж буй Харвардын Их Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 2 сарын 27–3 сарын 2 хооронд Эрүүл мэндийн яамнаас зарласан “Эрүүл мэндийн салбар дахь манлайлал” сэдэвт Зүүн өмнөд Азийн бүсийн тэтгэлэгт хөтөлбөрт Чанарын менежер Ж.Булган тэнцэж Малайз улсын Селангоор хотын “Sunway University”-д сургалтад оролцсон.<br> | Замын зардал, түр оршин суух , амжиргааны зардал өндөр байдагтай холбогдуулан суралцах хүсэлтэй ч санхүүгийн болоцоогүй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд гадаадын өндөр хөгжилтэй орнуудад суралцаж боловсрох боломжоос хоцорж байна. | Замын зардал, түр оршин суух , амжиргааны зардлын санхүүгийн туслалцаа үзүүлэх. | |
| 5. | Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бага эмч, эх баригч, | Бэлтгэгдсэн их эмчийн | | | Лавлагаа шалталын эмнэлэгт хамаарахгүй | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сувилагч нараас тухайн орон нутагт дутагдалтай байгаа их эмчийг захиалгаар бэлтгэх | тоо | | | | | | |
| 6. | Сум, сум дундын болон багийн эмнэлэгт 3 жил тогтвор суурьшилтай ажилласан эрэгтэй эмчийг цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцож, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах | Цэргийн дүйцүүлэх албыг хаасан эрэгтэй эмчийн тоо | | | Лавлагаа шалталын эмнэлэгт хамаарахгүй | | | |
| 7. | Сувилагч, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бусад эмнэлгийн их эмч, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнг улсын тсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад түлхүү хамруулах | Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан сувилагч, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бусад эмнэлгийн их эмч, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний тоо | | | Лавлагаа шалталын эмнэлэгт хамаарахгүй | | | |
| 8. | Их эмчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн сургалтыг өргөжүүлэн эмнэл зүйн чиглүүлэгч багшийн тоог нэмэгдүүлж, сувалхүйн мэргэшүүлэх сургалтыг удирдах сувилагч-сургагч | Их эмч болон сувилагчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч | 1-Сувилахуйн сургагч багш | 3-Эмнэл зүйн сургагч багш<br>2-Сувилахуйн сургагч багш | Эмнэлзүйн сургагч багшийн эзлэх хувь нийт эмч, сувилагч нарын-45,0% эзлэж байна.<br>2023 онд эмнэлзүйн сургагч багшийн, сувилахуйн сургагч багшийн сургалтад 3 эмч (Б. Лхагвасүрэн, Б.Сүхболд, Э.Дэлгэрзаяа), 2 сувилагч | Эмнэл зүй, сувилахуйн сургагч багшийн сургалтыг хувийн зардлаар зохион | Эмнэл зүй, сувилахуйн сургагч багшийн сургалтыг улсын зардлаар зохион | |

<table>
<tr><td></td><td>байгшийг үе шаттайгаар бэлтгэж эхлэх</td><td>байгшийн тоо</td><td></td><td></td><td>(Т.Оюунбилэг, Н.Оюунзул) сургахаар ЭМХТ-д албан бичиг хүргүүлсэн болов ч, энэ жилд үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх эрх авсан дүүрэг, нэгдсэн эмнэлэг, орон нутгийн эмнэлгүүдийг сургалтад хамруулж байгаа тул сургалтад хамрагдах хугацаа тодорхойгүй. ЭМХТ-ийн төлөвлөлтийн дагуу хамрагдана.<br>"Эмчийн сургагч багш бэлтгэх сургалт"-нд хамрагдах эмч мэргэжилтний мэдээлэл<br><table><tr><th>№</th><th>Овог</th><th>Нэр</th><th>Мэргэшил</th><th>Албан тушаал</th><th>Мэргэжлээрээ ажилласан жил</th><th>Сургалтад хамруулах хугацаа</th></tr><tr><td>1</td><td>Баасандорж</td><td>Лхагвасүрэн</td><td>Хүний их эмч, Дүрс оношилгооны эмч</td><td>Сургалтын албаны дарга</td><td>12</td><td>1-р хагас жил</td></tr><tr><td>2</td><td>Бямбаа</td><td>Сүхболд</td><td>Био-судлаач</td><td>Лабораторийн эмч</td><td>8</td><td>1-р хагас жил</td></tr><tr><td>3</td><td>Энхжаргал</td><td>Дэлгэрзаяа</td><td>Хүний их эмч, Арьс судлалын эмч</td><td>Эмгэг судлаач эмч</td><td>1</td><td>2-р хагас жил</td></tr></table><br>"Сувилахуйн сургагч багш бэлдэх сургалт"-нд хамрагдах сувилагч, тусгай мэргэжилтний мэдээлэл<br><table><tr><th>№</th><th>Овог</th><th>Нэр</th><th>Мэргэшил</th><th>Албан тушаал</th><th>Мэргэжлээрээ ажилласан жил</th><th>Сургалтад хамруулах хугацаа</th></tr><tr><td>1</td><td>Төрмөнх</td><td>Оюунбилэг</td><td>Сувилагч</td><td>Сувилагч</td><td>7</td><td>1-р хагас жил</td></tr><tr><td>2</td><td>Наранцэцэг</td><td>Оюунзул</td><td>Сувилагч</td><td>Сувилагч</td><td>7</td><td>2-р хагас жил</td></tr></table></td><td>байгуулдаг болсонтой холбоотой сургаглтанд хамрагдах хүсэлтэй эмч, сувилагч нарын тоо буурсан.</td><td>байгуулах.</td><td></td></tr>
<tr><td>9.</td><td>Лавлагаа шатлалын эмнэлгийн эмч, мэргэжилтнийг анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах боломжийг бүрдүүлэх</td><td>Анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах эрх, боломж</td><td>2</td><td>4</td><td>1. АӨСҮТ-ийн Харшлын лабораторын эрхлэгч, Биологийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Б.Сангидорж нарын судлаачид. “Харшлаас сэргийлэх арга хэмжээ” хүрээнд Ургамлын цэцгийн тоосны харшилаар өвчлөх гадаад, дотоод хүчин зүйл, эмгэг жам, дархлаажих үзэгдэл зүй механизм, оношилгоо эмчилгээний өвөрмөц аллерген үйлдвэрлэх инноваци технологи онол, арга зүйн суурь судалгааны гарсан үр дүн сэдэвт судалгааны ажил хийсэн.<br><br>2. АӨСҮТ-ийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, АУ-ны магистр, докторант Б.Батцэцэг “ Арьсны өвчний зайн оношилгоо. Эдийн засгийн үр ашиг” сэдэвт докторны судалгааны ажлын үр дүнгээр, АШУҮИС-ийн Эрдмийн чуулган-65, НЭМС салбар</td><td></td><td>Лавлагаа шатлалын эмнэлгийн эмч, мэргэжилтнийг анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах боломж бүрдсэн</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуралдаанд илтгэл хэлэлцүүлсэн, Эрдмийн чуулган 65 эмхэтгэлд хэвлэгдсэн.<br><br>3. АӨСҮТ-ийн сургалтын албаны дарга, дүрс оношилгооны эмч, АУ-ны магистр, докторант Б.Лхагвасүрэн “Арьсны хэт авиан шинжилгээ” сэдэвт ханын илтгэлээр “Монголын радиологийн чуулган- 2023” MCR 20238 эрдэм шинжилгээний хуралд оролцсон, Радиологи сэтгүүлд сургалтын өгүүлэл хэвлэгдсэн.<br><br>4. АӨСҮТ Поликлиникийн тасгийн их эмч Ч.Эрдэнэчимэг "Кандидийн төрлийн мөөгийг атопийн арьсны үрэвсэлтэй хүүхдүүдэд тодорхойлсон нь “ | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдэвт судалгааны ажлын үр дүнг, АШУҮИС Эрдмийн чуулган-65, АӨСҮТ ЭРдмийн чуулган VII шилдэг итлгэл, тус тус хэвлэгдсэн.   | | | |
| 10. | Эрүүл мэндийн байгууллагад ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нийтлэг журмыг баталж мөрдүүлэх | Батлагдсан журам; Журмын хэрэгжилт | | | 2023 оны эхний 2 дугаар улирлын байдлаар Монгол улсын Засгийн газрын 5Ш ажиллагааны хүрээнд удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт өгөөгүй түр томилогдсон байсан 2 албан тушаалтанг ажлаас чөлөөлж Ажлын хэсгийг байгуулан сонгон шалгаруулалтыг зарлаж Хүний нөөцийн албаны дарга, Аж ахуйн албаны дарга нарыг сонгон шалгаруулан авч томилсон байна. Тус төвд 2023 он гарсанаар жирэмсний амралтаа авсан 2, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 8, шинээр ажилд орсон 12 эмч, эмнэлгийн ажилтан байна. Сувилахуйн чиглэлээр шинээр төгссөн 3 оюутантай Хөдөлмөрийн гэрээ | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулан цаашид ажлын байраар хангах зорилгоор хамтран ажиллаж байна. | | | | |
| 11. | Эрүүл мэндийн байгууллага бүр шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, ажлын байранд дадлагажуулах сургалтыг зохион байгуулж хэвших | Ажлын байрны сургалтын хөтөлбөр; хамрагдсан ажилтны тоо | | | Шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ хийн, гүйцэтгэх захирлын тушаал, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулан баталгаажуулан, хувийн хэргийн бүрдлийг бүрдүүлэн, шинэ ажилтныг чиглүүлэх сургалтад хамруулан, байгууллагын фейсбүүк хуудсанд шинэ ажилтныг танилцуулан ажиллаж байна.<br><br>Шинэ ажилтныг чиглүүлэн сургах хөтөлбөрт шинээр орсон 11 ажилтныг хамруулсан байна. | | | | |
| 12. | Байгууллага нь ажилтан бүрийн ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлэх | Ажилтнуудын 70-аас доошгүй хувь нь жил бүр ур чадвараа хөгжүүлэх сургалтад хамрагдсан байх | | | Эхний хагасын байдлаар зэрэг ахиулах хүсэлтэй өгч шалгалтанд бэлдэнж байна. | | | | |
| 13. | Эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт сэлгэн ажиллуулах | Ажилласан эмнэлгийн мэргэжилтний тоо | 0 | 2 | 2023 оны 6 сарын 29-нд АӨСҮТ-ийн арьсны эмч Б.Номин Төв аймгийн Заамар суманд Туваан сангийн нэрэмжит 1 өдрийн хугацаатай арьсны үзлэг хийсэн. Арьсны үзлэгт нийт 30 хүн хамрагдаж эмчилгээ зөвлөгөө авсан, нийт хүмүүсийн 40% харшлын зовуурьтай, 2 хүн лавлагаа шатлалын оношилгоо, эмчилгээ шаардатай байсан тул АӨСҮТ-д үзүүлэхээр илгээсэн. | Ковид-19 цар тахлын улмаас лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт сэлгэн | Ковид-19 цар тахлын улмаас лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт сэлгэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллуулах үйл ажиллагаа түр тасалдсан | ажиллуулах үйл ажиллагаа түр тасалдсан ч 2023 оноос үе шатлалтайгаар орон нутгийн үзлэгийн үйл ажиллагааг дахин идэвжүүлж байна. | |
| **Гурав.Санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| 1. | Эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативыг тооцох аргачлалыг холбогдох байгууллагатай хамтран шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах | Батлагдсан аргачлал | | | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвд 2023 онд албан бичгээр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг илгээсэн | | | |
| 2. | Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгох | Эмч, эмнэлгийн ажилтны урамшуулал авсан тоо, мөнгөн дүн | | | Эрүүл мэндийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурыг боловсруулах ажлын хэсгийг 2022 оны 05 дугаар сарын 13 өдрийн А/26 тоот тушаалаар батлан ажиллаж байна. Үнэлгээний журам боловсруулах чанар, үр дүнтэй уялдуулан цалин, урамшуулал олгох эрх зүйн орчныг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллаж байна.<br>Цалин урамшуулал олгох эрх зүйн орчин шинэчлэгдэж гүйцэтгэлийг чанар, үр дүнтэй уялдуулан ажиллаж байна | | | |
| 3. | Эрүүл мэндийн ажилтны нэмэгдэл хөлсний талаар мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод | Дотоод аудитын тайлан | | | Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлд заасны дагуу цалин, нэмэгдэл хөлсийг олгож ажилласан.<br><br>Эмч, эмнэлгийн ажилтны илүү | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аудит хийх | | | | цагийн хөлсийг хөдөлмөрийн хуулийн дагуу олгож байна.<br><br>Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтанд хамтын гэрээ хөдөлмөрийн хуулийн дагуу 2%-иар тооцож олгож байна.<br><br>Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсийг хамтын гэрээний дагуу олгож байна. | | | |
| 4. | Өндөр өртөгтэй болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, мэргэжилтнүүдэд олгох эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх | Эмнэлгийн мэргэжилтэнд олгосон урамшууллын хэмжээ | | | Эхний хагасын жилийн байдлаар олголт хийгдээгүй байна. | | | |
| 5. | Эрүүл мэндийн байгууллага ажилтнууддаа зориулж, орон сууцны жишиг хотхон, хорооллыг барьж, байгуулахыг дэмжин газар, дэд бүтцийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн засаг, захиргааны байгууллага, бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах | Хэрэгжилт | | | 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан 2022-2024 оны Хамтын гэрээнд тусгасан байна. | | | |
| 6. | Зээл хүссэн эрүүл мэндийн ажилтанд бага хүүтэй цалингийн болон хэрэглээний зээл олгоход банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах | Бага хүүтэйцалингийн болон хэрэглээний зээл авсан эрүүл мэндийн ажилтны тоо | | | Хас банктхй хамтран ажиллах гэрээний хүрээнд цалинг олгож, цалингийн зээлийн мөн олгодог байсан бол Хаан банктай хамтран ажиллах гэрээг байгуулан харилцагч банк харгалзахгүй цахимаар онлайн цалинг олгож хамтран ажиллаж байна | | | |
| 7. | Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), | Гэр бүлийн гишүүдийн | | | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5.1.1 -т тус | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үр хүүхэд зэрэг гэр бүлийн аль нэг гишүүнд жилд нэг удаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх | тоо | | | төвийн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилго чиглэлийн дагуу ажилтан өөрөө эсвэл төрсөн эцэг, эх, нөхөр, эхнэр, үр хүүхэд нь өвчилсөн тохиолдолд тус төвд дараалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх, хэвтэн эмчлүүлэх заалтыг тусган өгсөн. 2022 онд 266 иргэн хамрагдсан байна. | | | |
| **Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжин, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн ажилтнуудын тоо, байршил, хуваарилалт, хүртээмж, төгсөлтийн дараах сургалтанд хамрагдалт, шилжилт хөдөлгөөний статистик мэдээллийг боловсронгуй болгох | Хүний нөөцийн мэдээний нэгдсэн сангаас гаргасан статистик мэдээлэл, бүртгэгдсэн ажилтны тоо / нийт ажилтны тоо гэх мэт | | | АӨСҮТөв нь Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд 143 ажилтан, 46 резидент эмч, ТУЗ-ын 6 гишүүн, Хүүхэд асрах чөлөөтэй 12 нийт 207 ажилтны үндсэн мэдээлэл, ажилт эрхлэлт, нэмэгдэл бүхий бүртгэлийг бүртгэсэн.<br>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн hr.hdc.gov.mn ашиглаж эмчлэх сувилах, эм барих эрхийн гэрчилгээг сунгах, мэргэжлийн зэрэг хамгаалах, батлах үйл ажиллагааг эхлүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Able бичиг хэрэг болон хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний программ<br>VERTECH LLC компанийн хүний нөөцийн программыг ашиглаж эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар нийт 152 ажилтан, 36 резидент эмчийн үндсэн мэдээлэл, ажил эрхлэлт болон цаг бүртгэлийн системийг бүрэн ашиглаж байна. | | | |
| 2. | Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээллийг эрүүл мэндийн албан ёсны статистик | мэдээний нэгдсэн санд бүртгэгдсэн ажилтны тоо / нийт | | | Тус төв Хөдөлмөрийн чадлаа алдсан нийт 6 эрүүл мэндийн ажилтан тогтвор суурьшилтай ажиллаж тэдгээрийн мэдээллийг тогтмол хүргэж байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээгээр бүртгэдэг болох | ажилтны тоо гэх мэт | | | | | | |
| 3. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааг тогтмолжуулж өргөжүүлэх | Нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааны тайлан | | | Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаагаар:<br><br>Нийт өрх толгойлсон 16 ажилтан, эмзэг ядуу 12 ажилтан, айлын хашаанд 5 ажилтан, түрээсийн байр, байшинд 15 ажилтан, гэрт 13 ажилтан, 6-8%-ийн зээлтэй 20 ажилтан, цалингийн зээлтэй 110 ажилтан гэх мэт нийгмийн хамгааллын судалгаа гарган дэмжлэгт удирдлагаар хангах талаар үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Судалгааг жилийн эцсээр нэг удаа авч байна. | | | |
| 4. | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг бүр ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үйл ажиллагааг орон нутаг, байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх | Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, биелэлт | | | Сувилахуйн чиглэлээр шинээр төгссөн 3 оюутантай Хөдөлмөрийн гэрээ байгуулан цаашид ажлын байраар хангах зорилгоор хамтран ажиллаж байна. Хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарч байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж халдварын нөхцөлийг нэмэгдлийг нийт сувиллагч нарт олгож дэмжин туслах үйлчилгээний ажилчдын цалинг үе шаттайгаар нэмэж ажиллаж байна. Эдийн засагч, нягтлан бодогч, нярав, IT инженер, архив номын санч, захирлын туслах зэрэг дэмжих ажилчдын үндсэн цалинг тус бүр 10 хувиар нэмэгдүүлсэн байна. Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран Хамтын гэрээг хэлэлцэн баталсан байна. Хамтын гэрээний хэлэлцээрийн хүрээнд илүү цагийг дундаж цалин хөлснөөс, шөнийн цагийн нэмэгдлийг 1000 төгрөг байсныг 2000 төгрөг болон нэмэгдүүлж, | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мөн үндсэн цалинг 6-8 хувиар нэмэгдүүлэхээр эдийн засгийн тооцоог гарган хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Эхний 1-р улиралд гүйцэтгэлийн урамшуулалд 97,852,247 төгрөг, 2-р улирлын урамшуулал 61,554,709 төгрөг, Төрийн дээд шагнал хүртсэн Монгол улсын гавьяат зүтгэлтэнд 2,000,000 төгрөг, Алтан гадас одонт 2 ажилтан тус бүр 300,000 төгрөг, хөдөлмөрийн хүндэт медаль 1 ажилтан 200,00 төгрөгийн урамшуулал олгосон байна. Жилийн эцсийн гүйцэтгэлээр хангалттай үнэлэгдсэн даатгалын мэргэжилтэнд 3 сар үндсэн цалингийн 40 хувиар, Санхүүгийн балансийн урамшуулалд нийт ажилтанд 15,527,190 төгрөгийн урамшуулал, 4 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж мөн цалинтай чөлөө 22, цалингүй чөлөөг 17 удаа олгосон байна. | | | |
| 5. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн шилдэг санаачлага, үйл ажиллагааг шалгаруулж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх | Түгээн дэлгэрүүлсэн шилдэг туршлага, үйл ажиллагааны тоо | | | ARSLAN.MN сайт болон байгууллагын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд цаг үетэй холбогдолтой мөн арьсны зонхилон тохиолддог өвчлөлүүд хэрхэн урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг цаг алдалгүй тухайн бүрд нь мэдээллийг түргэн шуурхай мэдээлж байна. Мөн арьсны төрөл, арьс арчилгаа, арьсны идээт өвчнүүд, ургамлын тоосонцрын харшил гэх мэт хичээлүүдийг хүлээлгийн танхим, амбулаторийн ТВ-ээр тасралтгүй хүргэж байна | | | |
| 6. | Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран | Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн | | | Төвийн албан ёсны пейж хуудас болон Zaag.mn тогтмол мэдээ мэдээлэл оруулан ажиллаж | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллах | онцлог, үйл ажиллагааг сурталчилсан мэдээ, нэвтрүүлэг | | | байна. | | | |
| 7. | Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудсыг эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудастай холбох, үйл ажиллагааг тогтмолжуулах | Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудасны хандалтын тоо | | | Арьсны өвчин судлалын үндэсний төвийн албан ёсны сайт derma.gov.mn болон zangia.mn сайтад сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг тогтмол тавин ажиллаж derma.gov.mn-ээр 12 нээлттэй ажлын байрны зарыг оруулж, zangia.mn-ээр 86 сонгон шалгаруулалтын материал хүлээн авсан байна. | | | |